



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№45 /259/ 2022.03.07

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

**Бүсгүй минь чи инээмсэглэж яваарай!**



Цаг үе, үйл явдал

## АХМАДУУДАА ХҮНДЭТГЭВ

Монгол цэргийн өдөр болон Зэвсэгт хүчний 101 жилийн ойн тохиолдуулан Төрийн тусгай хамгаалалтын газраас бэлтгэл болон чөлөөнд гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлж Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медалийг гардуулан өглөө. Энэ үеэр Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай "Хүннү гүрний үеэс үүсэж, Их Монгол Улсын үеэс хүчирхэгжин бэхжиж ирсэн эртний түүхтэй байгууллагад Монгол Улсынхаа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамтран зүтгэж, Монгол төрийн аюулгүй байдлыг сахин хамгаалах нэн хариуцлагатай үүргийг нэр

төртэй биелүүлж ирсэн Төрийн тусгай хамгаалалтын газраас бэлтгэл болон чөлөөнд гарсан ахмадууд та бүхэндээ удахгүй болох Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярын дайчин цогтой мэндийг өргөн дэвшүүлье. Та бүхэн Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасны дагуу Төрийн өндөрлөг, гадаад орны төр засгийн тэргүүн, өндөр дээд хэмжээний зочид болон бусад хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангаж иж бүрэн, найдвартай, шуурхай хамгаалалт, үйлчилгээг үзүүлэх үүргээ нэр төртэй гүйцэтгэж ирсэнийг энд дурдахад таатай байна" гэлээ.



## ЭМЭГТЭЙЧҮҮДДЭЭ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ЗХЖШ болон Зэвсэгт хүчний Төрийн цэргийн

командлалууд, инженерийн цэргийн газрын удирдлагагад олны зүгээс тус байгууллагын эмэгтэй

ажилтан, алба хаагчиддаа хүндэтгэл үзүүлж гарын бэлгийг гардуулан өглөө. Энэ үеэр ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал

Д.Ганзориг нийт эмэгтэйчүүддээ зориулж баярын халуун мэндийг дэвшүүлж, цаашдын ажил албанд нь өндөр амжилтыг хүсэн ерөө.



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,271,724 /69.8%!	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,173,135 /66.8%!	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,025,368 31,5% 105,671 /3,2%!
НИЙТ БАТЛАГДСАН 8354 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 96	ЭДГЭРСЭН 8164

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 442,331,939
Эдгэрсэн Нийт: 374,931,028
Нас барсан Нийт: 6,001,494

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
Өдөр	Шөнө
-5	-15
ӨМНӨД СУДАН	
Өдөр	Шөнө
42	28

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,876.00	2,885.0
EUR	3,200.0	3,230.0
CNY	455.00	456.50
RUB	33.00	36.00
JPY	25.00	25.15
KRW	2.40	2.41

## ЗУРХАЙ

2022.03.07 ДАВАА ГАРАГ  
/БИЛГИЙН ТООЛЛЫН 5/

**ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН  
ТУУЛАЙ САРЫН ЕСӨН УЛААН  
ШАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Эд мал, ариажина  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
07.22-18.45  
**Барилдлага:**  
Үхэх  
**Шүтэн барилдлага:**  
Сэрэхүй  
**Суудал:** Хий

Энэ өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лус тахиx, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

**Иргэн ТА**

**1 ТУНД** • 12 нас хүрсэн бол, Жирэмсний хугацаа 14-36 долоо хоногийн хооронд баргаа бол,

**2 ТУНД** • 1-р тундаа хамрагдаа 21 хоногсон бол,

**ДАРХЛАА СЭРГЭЭХ НЭМЭЛТ ТУНА**

18 нас хүрсэн :

- Дархлаажуулагчийн 2 бүрэн тунд хамрагдсан, 3 сар өнгөрсөн бол /ковидоор өвчөөгүй үед/
- Дархлаажуулагчийн 2 тунд хийгээд коронавируст халдваралт ороод элгэрсэн одоос хойш 21 хоног өнгөрсөн бол

**ХАРИН ТА:** Дархлаажуулагчийн 1 дэх тунд хамрагдаа ямар нэг шалтгааны уамас давтан тундаа хамрагдаагүй 3 сарын хугацаа өнгөрсөн бол 2 тунд вакцин хийгээд.

**ТА ӨРИЙН ЭМНЭЭГЭЭ ОЧИЖ ВАКЦИНДАА ХАМРАГААРАЙ**

Цахим шууданд

# БАЙР ЗҮЙЧДИЙН ТУСГАЙ ТАКТИКИЙН ХЭЭРИЙН СУРГУУЛЬ АНХ УДАА



**Зэвсэгт хүчний 284 дүгээр анги**

Ангийн 2021-2022 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу сургуулийн жилийн нэгдүгээр үеийн хэерийн гаралт, полигоны дадлагыг 2 дугаар сарын 28-наас энэ сарын 4-ний өдрүүдэд явууллаа.

Хэерийн гаралт, полигоны дадлагыг "БЗГБ ангийн байнгын байрлалаас хүч хуралдуулах районд гарч байр зүй, геодизийн

хангалтыг зохион байгуулах ажиллагаа" сэдвээр 3 үе шаттайгаар амжилттай зохион байгуулж явуулав.

Хэерийн гаралт, полигоны дадлагын төлөвлөлтийн баримт бичгүүдийг бүрэн хэмжээнд боловсруулж, сургууль, дадлага явуулах бүх төрлийн бэлтгэл ажлыг сайтар хангасны үндсэн дээр нэгдүгээр шат, ангийн байнгын байрлалаас хөдөлгөөн эхэлж Амгалан дулааны станц ххк, Шижир

амралтын уулзвар зам, өндөрлөг 1326.0, Туул гол амралтын газар, Найман шарга амралтын район чиглэлд 60 км-ийн явган марш үйлдэн хоногийн сургуулийг явуулав. Хоёрдугаар шатанд хэерийн байрлалын районд бие бүрэлдэхүүнтэй төлөвлөгөөт дадлагын сургалт болон томилгоот тасаг бүлгийн бүрэлдэхүүнтэй байр зүй геодизи, орон зайн тагнуул болон цаг уурын хангалтыг байгуулах сэдвээр штабын

бэлтгэл сургалтыг амжилттай хэрэгжүүллээ.

Төгсгөлд нь буюу гуравдугаар шатанд "Байр зүй геодизийн хөдөлгөөний бүлэг дайсны тагнуул, хорлон сүйтгэх бүлэгтэй тэмцэл явуулах" сэдвээр тасгийн байлдааны буудлагыг амжилттай зохион байгуулсан юм.

Тус "Байр зүй геодизийн хөдөлгөөний бүлэг дайсны тагнуул, хорлон сүйтгэх бүлэгтэй тэмцэл явуулах" сэдэвт

тасгийн байлдааны буудлага нь ангийн хувьд анх удаа зохион байгуулагдаж буй сургалт дадлага бөгөөд хэерийн гаралт полигоны дадлагын явц болон тасгийн байлдааны буудлагыг ЗХЖШ-ын АУГ-ын суртал хүмүүжил, мэдээлэл, сэтгэл зүйн хангалтын хэлтсийн дарга хурандаа Ц.Батсайхан, мэргэжилтэн дэд хурандаа О.Ганбаяр нар хуралцан ирж үйл ажиллагаатай танилцан ангийн удирдлагатай санал

сэтгэгдлээ солилцсон юм.

Ийнхүү гурван өдрийн турш үргэлжилсэн дээрх арга хэмжээ нь ангийн сургалт, дадлага төлөвлөгөөний дагуу осол, зөрчилгүй явагдсан бөгөөд бие бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлжилт, сэтгэл зүйн бэлтгэл, мэргэжлийн дадлага ур чадварыг тодорхой түвшинд нэмэгдүүлж, үр дүнтэй явагдсан юм.

**Ахлах дэслэгч М.ОЧГЭРЭЛ**



## МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТАД ХАМРАГДАВ

**Зэвсэгт хүчний 017 дугаар анги**

Тус ангийн ахлагч, хугацаат албаны түрүүч, байлдагч нар Техник технологийн политехникийн коллежид барилгын өргөн мэргэжил, хүнд машин механизмын засварчин, автомашины засварчин, өргөн тээвэрлэх тоног төхөөрөмжийн засварчин, компьютерийн оператор зэрэг мэргэжлүүдээр мэргэжлийн

боловсрол олгох сургалтад өнгөрөгч 1 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн хамрагдаж буй юм.

Дээрх сургалтын онолын хичээлийг ангийн байрлалд Техник технологийн политехникийн коллежийн багш нар хуралцан ирж явуулсан бол, дадлагыг тус сургуулийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулж байна.

Тухайн сургалтын

онцлог нь ангийн хугацаат цэргийн алба хаагчид бүгд мэргэжил эзэмшихээс гадна ахлагч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлд илүү анхаарч байна. Мөн 2022 онд цэргийн алба хаасны тэтгэвэрт гарах ахлагч нарт ангийн мэргэжил эзэмшүүлэх сургалтыг тус сургуультай хамтарч явуулж байна.

**Тэргүүн ахлагч А.ЦЭРЭНТОГТОХ**

